

## **ГАДААДЫН БАНКНЫ САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ ТОГТООХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**

### **НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Энэ журмын зорилго нь Банкны тухай хуулийн 22 дугаар зүйл, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг үндэслэн гадаад улсад үүсгэн байгуулагдсан банк (цаашид “гадаадын банк” гэх)-ны салбар, төлөөлөгчийн газар Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Банкны салбар нь хуулийн этгээдийн эрхгүй бөгөөд Монголбанкнаас зөвшөөрсөн үйл ажиллагааг эрхэлнэ.

1.3.Гадаадын банкны салбарын бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны чиглэл, хэмжээ, бүтэц, хүний нөөц, ажлын байр зэргийг харгалзан Монголбанк нэмэлт шаардлага тавьж, эрхлэх үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоож болно.

1.4.Гадаадын банк Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газар байгуулах тухай бүр Монголбанкнаас зөвшөөрөл авна.

### **ХОЁР. ГАДААДЫН БАНКНЫ САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХЭД ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА**

2.1.Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх гадаадын банкны салбар, төлөөлөгчийн газар нь дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна.

2.1.1.Банкны тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байх;

2.1.2.банкны салбар, төлөөлөгчийн газар байгуулах хүсэлт гаргасан өдрөөс өмнөх 3 -аас багагүй жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа эрхэлсэн байх;

2.1.3.банкны харьяалагдах улсын хяналт шалгалтын эрх бүхий байгууллагаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хүсэлт гаргасан өдрөөс өмнөх 1 жилийн хугацаанд тогтмол хангаж ажилласан байх;

2.1.4.банкны харьяалагдах улсад хийгддэг банкны зохистой засаглалын үнэлгээ нь “Дунд” (эсхүл үүнтэй адилтгах) ба түүнээс дээш байх;

2.1.5.гадаадын банк нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй, эсхүл ял шийтгэлийн хугацаа дууссан байх;

2.1.6.Монгол Улсад банкны салбар, төлөөлөгчийн газар байгуулахыг харьяалах улсын хяналт шалгалтын эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн байх;

2.1.7.Банкны харьяалагдах улсын хяналт шалгалтын эрх бүхий байгууллага нь банкны Монгол Улсад байгуулах салбарт банкны хяналт шалгалтыг хэрэгжүүлэх боломжтой байх;

2.1.8.Монголбанк нь гадаадын банкны Монгол Улсад байгуулах салбарт хэрэгжүүлэх банкны хяналт шалгалтын үйл ажиллагааг банкны харьяалагдах улсын хяналт шалгалтын эрх бүхий байгууллагатай хамтран, эсхүл түүгээр дамжуулан хэрэгжүүлэх боломжтой байх;

2.1.9.Банкны тухай хуулийн 65 дугаар зүйлд заасан банкны нэгдэлд авах бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг Монголбанк нь гадаадын банкны харьяалагдах улсын хяналт шалгалтын эрх бүхий байгууллагатай хамтран, эсхүл түүгээр дамжуулан хэрэгжүүлэх боломжтой байх;

2.1.10.гадаадын банк нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21.1-д заасан хуулийн этгээд бол салбар байгуулахыг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвшөөрсөн байх;

2.1.11.гадаадын банкны салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд нь Банкны тухай хуулийн 34.2-т заасан шаардлагыг хангасан байх;

2.1.12.гадаадын банкны салбар нь ажлын байр, техник тоног төхөөрөмж, програм хангамж, найдвартай аюулгүй ажиллагаатай холбоотой Монголбанкны шаардлагыг хангасан байх;

2.1.13.банк, санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх.

2.2.Гадаадын банкны салбар нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэхгүй байх.

## **ГУРАВ.ГАДААДЫН БАНКНЫ САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХҮСЭЛТ ГАРГАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ**

3.1.Энэ журмын 2.1-т заасан нөхцөл, шаардлагыг хангасан Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх гадаадын банкны салбар, төлөөлөгчийн газар нь дараах баримт бичгийг Монголбанканд ирүүлнэ.

3.1.1.энэ журмын Хавсралт 1-ийн дагуу гаргасан, банкны салбар байгуулах албан хүсэлт;

3.1.2.банкны гэрчилгээ (цахим эсхүл цаасан хуулбар);

3.1.3.банкны дүрэм (цахим эсхүл цаасан хуулбар);

3.1.4.банкны салбар, төлөөлөгчийн газрын дүрэм (эсхүл адилтгах баримт бичиг);

3.1.5.гадаадын банкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц, эзэмшлийн хувь хэмжээний талаарх мэдээлэл;

3.1.6.Банкны тухай хуулийн 22.1-д заасан баримт бичиг;

3.1.7.гадаадын банкны сүүлийн 3 жилийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн олон улсад нийтээр дагаж мөрдөх стандартын дагуу баталгаажуулсан санхүүгийн тайлан;

3.1.8.энэ журмын 2.1.3, 2.1.4-д заасан шаардлагыг хангаж байгааг нотлох баримт бичиг;

3.1.9.банкны салбар байгуулах эдийн засгийн үндэслэл, бизнес төлөвлөгөө;

3.1.10.гадаадын банкны харьяалагдах улсын хяналт шалгалтын эрх бүхий байгууллагаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийн биелэлтийг сүүлийн 3 жилийн байдлаар;

3.1.11.банк нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцож байгаагүй эсхүл ял шийтгэлийн хугацаа нь дуусаныг нотлох баримт бичиг;

3.1.12.банкны салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд энэ журмын Хавсралт 2-ын дагуу гаргасан тодорхойлолт болон тус этгээд нь Банкны тухай хуулийн 34.2-т заасан шаардлагыг хангаж байгааг нотлох баримт бичиг;

3.1.13.энэ журмын Хавсралт 3-ын дагуу гаргасан техник, тоног төхөөрөмж, ажлын байрны тодорхойлолт.

## **ДӨРӨВ.ТАЙЛАГНАХ**

4.1.Гадаадын банк, гадаадын банкны Монгол Улс дахь банкны салбарын үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан болон банкны хяналт шалгалтын хэрэгцээнд зориулсан бусад тайланг гадаадын банкны харьяалагдах улсын хяналт шалгалтын эрх бүхий байгууллагатай байгуулсан Хамтын ажиллагааны гэрээ эсхүл Харилцан ойлголцлын санамж бичигт заасан хугацаанд Монголбанканд ирүүлнэ.

4.2.Гадаадын банкны төлөөлөгчийн газар нь үйл ажиллагааны тайланд энэ журмын Хавсралт 4-т заасан мэдээллийг тусган, улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 05-ны өдрийн дотор цаасан болон цахим хэлбэрээр Монголбанкинд ирүүлнэ.

4.3.Монголбанк гадаадын банкны салбар, төлөөлөгчийн газарт шаардлагатай тохиолдолд газар дээрх хяналт шалгалт хийж болно.

4.4.Гадаадын банк Монгол Улсад байгуулсан банкны салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгах тухай бүр Монголбанканд мэдэгдэнэ.

4.5.Гадаадын банк салбар, төлөөлөгчийн газраа татан буулгахдаа дараах мэдээлэл, баримт бичгийг Монголбанканд ирүүлнэ.

4.5.1.Банкны салбарыг татан буулгах үндэслэл, тайлбар бүхий албан бичиг;

4.5.2.Банкны салбарыг татан буулгах тухай банкны шийдвэр;

4.5.3.Бусдад өгөх өглөг буюу харилцагч, хадгаламж эзэмшигчийн мөнгөн хөрөнгө;

4.5.4.Засгийн газрын сангийн болон бусад мөнгөн хөрөнгө;

4.5.5.Бусад хэлцлээс үүдэлтэй бусдын өмнө хүлээсэн үүрэг;

4.5.7.Бусдаас авах авлага буюу зээл, түүнтэй адилтгах бусад актив;

4.5.8.Шүүх, хууль хяналтын байгууллагаар хянан хэлцэгдэж байгаа болон шалгагдаж байгаа аливаа хэрэг маргаан.

## ТАВ. ХЯНАЛТ ХАРИУЦЛАГА

5.1.Монголбанк энэ журмын биелэлтэд хяналт тавьж, Банкны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

\_\_\_ оОо \_\_\_

**ГАДААДЫН БАНКНЫ САЛБАР/ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР  
БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТ**

|   |   |  |                |
|---|---|--|----------------|
| <b>1. Банкны салбар/төлөөлөгчийн газар байгуулах банкны нэр</b>   |   |  |                |
|   |   |  |                |
| <b>2. Банкны салбар/төлөөлөгчийн газрын оноосон нэр</b>   |   |  |                |
|   |   |  |                |
| <b>3. Банкны салбар/төлөөлөгчийн газрын хаяг</b>  |   |  |                |
|   |   |  |                |
| <b>4. Банкны салбар/төлөөлөгчийн газрын эрхлэх үйл ажиллагаа</b>  |   |  |                |
|   |   |  |                |
| <b>5. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц</b>  |   |  |                |
| Хувьцаат компани бол бүртгэлтэй хөрөнгийн биржийн нэрийг бичнэ үү.  |   |  |                |
| Нийт саналын эрхтэй хувьцааны 5%-аас дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигчдийн нэрийг, эзэмшлийн хувьтай нь бичнэ үү. |   |  |                |
| д/д   | Хувьцаа эзэмшигчийн оноосон нэр (овог, нэр) | Эзэмшлийн хувь                         |                |
| 1   |   |  |                |
| 2   |   |  |                |
| ...   |   |  |                |
| Хараат болон охин компанитай бол компанийн нэр, эзэмшлийн хувийг бичнэ үү.  |   |  |                |
| д/д   | Компанийн нэр                               | Хараат эсхүл охин компани аль нь болох | Эзэмшлийн хувь |
| 1   |   |  |                |
| 2   |   |  |                |
| ...   |   |  |                |
| Өөр хуулийн этгээд эсхүл банканд хувь эзэмшдэг бол оноосон нэр, эзэмшлийн хувийг бичнэ үү.                            |   |  |                |
| д/д   | Хуулийн этгээдийн нэр                       | Эзэмшлийн хувь                         |                |
| 1   |   |  |                |
| 2   |   |  |                |
| ...   |   |  |                |
| Аливаа нэг хуулийн этгээдийн охин эсхүл хараат компани бол тухайн компанийн нэр, эзэмшлийн хувийг бичнэ үү.           |   |  |                |

| д/д   | Хуулийн этгээдийн нэр  | Эзэмшлийн хувь   |
|---|--|------------------|
| 1   |  |                  |
| 2   |  |                  |
| ...   |  |                  |
| <b>6. Банкны эрх бүхий албан тушаалтнууд</b>  |  |                  |
|   | <u>Албан тушаал</u>  | <u>Овог, нэр</u> |
| 1   |  |                  |
| ...   |  |                  |
| <b>7. Харьяалагдах улсаас бусад улс дахь үйл ажиллагаа</b>  |  |                  |
| Харьяалагдах улсаас бусад улс дахь салбар, төлөөлөгчийн газар, охин компанийн оноосон нэр, байршлыг бичнэ үү.   |  |                  |
| д/д   | Салбар, төлөөлөгчийн газар, охин компанийн оноосон нэр       | Хаяг             |
| 1   |  |                  |
| 2   |  |                  |
| ...   |  |                  |
| Харьяалагдах улсаас бусад улсад салбар, төлөөлөгчийн газар, охин компани байгуулах хүсэлт гарган татгалзсан хариу авч байсан бол тухайн улсын нэр, хүсэлт гаргасан огноо, татгалзсан шалтгааныг бичнэ үү.   |  |                  |
| <b>8. Санхүүгийн үзүүлэлт</b>   |  |                  |
| Сүүлийн 3 жилийн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа, нийт өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтийг он дарааллаар оруулна уу.  |  |                  |
| Сүүлийн 3 жилийн харьяалагдах улсаас бусад улс дахь үйл ажиллагааны нийт актив болон орлогын хэмжээг он дарааллаар оруулна уу.  |  |                  |
| Он  | Гадаад дахь үйл ажиллагааны нийт активын хэмжээ (ам. доллар) |                  |
| ...   |  |                  |
| ...   |  |                  |
| <b>9. Албадлагын арга хэмжээ</b>  |  |                  |
| Харьяалагдах улс болон бусад улсын хяналт шалгалтын асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагаас танай банк, санхүүгийн байгууллагад албадлагын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн бол авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, авах үндэслэл, шалтгаан, огноо болон эрх бүхий байгууллагын нэрийг бичнэ үү. |  |                  |
| Танай банк, санхүүгийн байгууллага, салбар, төлөөлөгчийн газар, охин болон хараат компани, тэдгээрийн гүйцэтгэх удирдлага сүүлийн 3 жилд шүүх, хуулийн байгууллагын ял, шийтгэлтэй бол огноо болон ял шийтгэлийг бичнэ үү.  |  |                  |
| <b>10. Хүсэлтэд хавсаргасан баримт бичгийн жагсаалт</b>   |  |                  |
| 1   |  |                  |

|  |  |
|--|--|
| 2  |  |
| 3  |  |
| ...  |  |
| <i>Бүгд ..... хуудас</i>   |  |
| <i>Дээрх баримт бичгийг Банкны тухай хууль, "... журам"-ын дагуу үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа, хуурамч мэдээлэл орсон тохиолдолд Банкны тухай хуулийн дагуу хариуцлага хүлээх болно.</i> |  |

Хүсэлт болон холбогдох баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, банкны салбар/төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрлийг олгоно уу.

ХҮСЭЛТ ГАРГАСАН:

Гүйцэтгэх захирал

(гарын үсэг)

(нэр)

## ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ТОДОРХОЙЛОЛТ

| ТОМИЛОГДОХ АЛБАН ТУШААЛ  |                                       |                         |   |                                  |
|--|---------------------------------------|-------------------------|---|----------------------------------|
| <i>(томилогдох албан тушаалын нэрийг энд бичнэ үү)</i>   |                                       |                         |   |                                  |
| <b>I. Товч танилцуулга</b>   |                                       |                         |   |                                  |
| Ургийн овог:   |                                       | цээж зураг              |   |                                  |
| Овог:  |                                       |                         |   |                                  |
| Нэр:   |                                       |                         |   |                                  |
| Төрсөн огноо:  |                                       |                         |   |                                  |
| Регистрийн дугаар:   |                                       |                         |   |                                  |
| Иргэншил:  |                                       |                         |   |                                  |
| Оршин суугаа хаяг:   |                                       |                         |   |                                  |
| Цахим шуудангийн хаяг:   |                                       |                         |   |                                  |
| Утасны дугаар:   |                                       |                         |   |                                  |
| <b>II. Боловсрол</b> <i>(боловсролын гэрчилгээний хуулбарыг хавсаргана уу)</i>                     |                                       |                         |   |                                  |
| Боловсрол  | Эзэмшсэн боловсрол/<br>хамгаалсан цол | Суралцсан<br>хугацаа    | Сургуулийн нэр                                | Улс, хотын нэр                   |
| ...  |                                       |                         |   |                                  |
| ...  |                                       |                         |   |                                  |
| <b>III. Ажил эрхлэлт</b>   |                                       |                         |   |                                  |
| Одоо ажиллаж байгаа байгууллага  |                                       |                         |   |                                  |
| Албан тушаалын нэр   |                                       |                         |   |                                  |
| Албан тушаалд томилогдсон огноо  |                                       |                         |   |                                  |
| Ажлын чиг үүрэг  |                                       |                         |   |                                  |
| Ажлын хаяг, утасны дугаар  |                                       |                         |   |                                  |
| Өмнөх хугацаанд<br>ажилласан<br>байгууллага  | Албан тушаалын нэр                    | Ажлын чиг<br>үүрэг      | Албан<br>тушаалд<br>томилогдсон<br>огноо      | Ажлаас гарсан<br>огноо, шалтгаан |
| ...  |                                       |                         |   |                                  |
| ...  |                                       |                         |   |                                  |
| Хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан бол доорх хүснэгтийг бөглөнө үү.                       |                                       |                         |   |                                  |
| д/д  | Оноосон нэр,<br>Бүртгэлтэй улсын нэр  | Улсын бүртгэлийн дугаар | Регистрийн дугаар                             |                                  |
| 1  |                                       |                         |   |                                  |
| 2  |                                       |                         |   |                                  |
| ...  |                                       |                         |   |                                  |
| Хуулийн этгээд, банкны хувьцаа эзэмшдэг бол доорх хүснэгтийг бөглөнө үү.                           |                                       |                         |   |                                  |
|  | Оноосон нэр,<br>Бүртгэлтэй улсын нэр  | Эзэмшлийн хувь          | Улсын бүртгэлийн дугаар,<br>Регистрийн дугаар |                                  |
| 1  |                                       |                         |   |                                  |
| ...  |                                       |                         |   |                                  |
| <b>IV. Гэр бүлийн байдал</b> <i>(гэр бүлийн гишүүд, хамтран амьдрагчийн мэдээллийг оруулна уу)</i> |                                       |                         |   |                                  |



|     | Овог, нэр,<br>Регистрийн дугаар | Таны юу болох | Одоо эрхэлж байгаа ажил,<br>албан тушаал |
|-----|---------------------------------|---------------|--|
| 1   |                                 |               |  |
| ... |                                 |               |  |

Иргэний үнэмлэх/паспортын хуулбарыг хавсаргав.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

(нэр)

(гарын үсэг)

..... оны ..... сарын .....-ний өдөр

..... **БАНКНЫ САЛБАРЫН**  
**ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

Банкны салбар нь үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр бүрэн хангагдсан бөгөөд үйл ажиллагаандаа ..... (*програм хангамжийн нэрийг бичнэ*) програм хангамж ашиглаж, програм хангамж нь мэдээллийн нууцлал, найдвартай ажиллагааг хангасан болохыг баталж байна.

Банкны салбар нь үйл ажиллагаа эрхлэхэд зориулж Улаанбаатар хот (..... аймаг)-ын ..... (хаяг) байршилтай үл хөдлөх хөрөнгийг худалдан авсан (түрээсэлсэн) (аль нь болохыг доогуур нь зурах) бөгөөд Энэ байр нь нийт .....метр квадрат талбайтай, банкны үйл ажиллагаа эрхлэхэд тохиромжтой бөгөөд банкны аюулгүй ажиллагааг хангах харуул хамгаалалтын ..... компанитай болон дохиолол хамгаалалтын ..... компанитай гэрээ байгуулахаар тохиролцсон болно.

Хавсралт:

1. Банкны үйл ажиллагаа эрхлэх үл хөдлөх хөрөнгийг худалдаж авсан бол үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар, зээлийн барьцаанд байгаа эсэхийг тодорхойлсон баримт бичиг, түрээсэлсэн бол түрээсийн гэрээ.
2. Банкны програм хангамжийг нийлүүлж байгаа этгээдтэй хийсэн гэрээ, Монголбанкны банк хоорондын сүлжээ болон зээлийн мэдээллийн сантай холбогдож, ажиллахад бэлэн болсныг нотлох баримт.
3. Харуул хамгаалалтын болон дохиолол хяналтын компанитай байгуулсан гэрээ (эсхүл гэрээ байгуулахаар урьдчилан тохирсон болохыг нотлох баримт).

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

(гарын үсэг)

(нэр)

## ГАДААДЫН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН УЛИРЛЫН ТАЙЛАН

Гадаадын банк, санхүүгийн байгууллагын төлөөлөгчийн газар нь улирлын үйл ажиллагааны тайландаа дараах мэдээллийг тусган, дараа улирлын эхний сарын 05-ны өдрийн дотор цаасан болон цахим хэлбэрээр Монголбанкинд ирүүлнэ. Үүнд:

1. Төлөөлөгчийн газрын бүтэц, бүрэлдэхүүн;
2. Тайлант улиралд Монгол Улсын банк, санхүүгийн байгууллагуудтай явуулсан хамтын ажиллагаа, харилцаа тогтооход туслалцаа үзүүлж байгаа эсэх;

Тайлант улиралд Монгол Улсын аж ахуйн нэгжүүдэд зуучилсан санхүүжилтийн талаарх мэдээлэл. Тухайлбал, санхүүжилт олгосон банкны байршил, нэгж, хугацаа, огноо, нөхцөл, дүн, төлөлт, үлдэгдэл, хамтран ажилласан байгууллагууд гэх мэт;

- 3.
4. Төлөөлөгчийн газраас зуучилж санхүүжилт олгохоор судалж буй төслүүдийн талаарх мэдээлэл;
5. Тус банкны төв салбараас Төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж буй эсэх;
6. Төлөөлөгчийн газар байгуулагдсанаас хойших хугацаанд банкнаас Монгол Улсын байгууллага, аж ахуйн нэгжүүдэд зуучилсан санхүүжилтийн талаарх мэдээллийг дүн, төлөлт, үлдэгдэл, хамтран ажилласан байгууллагуудын нэрс;